



**МОНГОЛ УЛСЫН СТАНДАРТ**

---

**Хүүхдийн зуслангийн үйл ажиллагаа  
Ерөнхий шаардлага**

**MNS 5633:2023**

Албан хэвлэл

**Стандарт, хэмжил зүйн газар  
Улаанбаатар хот**

**2023 он**

АНХН СТАНДАРТ БОЛГОХ ТӨВРИЙН НИД ЭЛГӨВ  
СТАНДАРТ ХЭМЖИЛ ЗҮЙН ГАЗАР, 2023.09.04  
МОНГОЛ УЛСЫН СТАНДАРТ МӨН, ХУВИЛАН ОЛШРУУЛАХЫГ ХЭНГЭГ ЛӨНӨ

## **MNS 5633:2023**

### **Өмнөх үг**

Стандарт, хэмжил зүйн газар (СХЗГ) нь Олон улсын стандартчиллын байгууллагын жинхэнэ гишүүн бөгөөд үйл ажиллагааныхаа хүрээнд төрийн болон төрийн бус олон нийтийн байгууллагуудтай хамтран үндэсний стандарт боловсруулах ажлыг зохион байгуулдаг.

Үндэсний стандартын төсөл боловсруулах ажлыг салбарын техникийн хороогоор дамжуулан гүйцэтгэдэг бөгөөд Техникийн хороодоор хэлэлцэж дэмжсэн, зөвшилцөлд хүрсэн стандартын төслийг Стандарт, хэмжил зүйн газрын даргын тушаалаар баталснаар улсын хэмжээнд хүчин төгөлдөр болно.

Энэхүү стандартыг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Гэр бүлийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Н.Баярмаа, Гэр бүлийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын Хүүхэд залуучуудын хөгжлийн хэлтсийн хүүхдийн хөгжил, оролцооны бодлого, зохицуулалт хариуцсан мэргэжилтэн Д.Бат-Эрдэнэ, зөвлөх АУ-ы доктор Ц.Бурмаа нар боловсруулж, СХЗГ-ын мэргэжилтэн Х.Осгонтуяа “MNS 1-2:2022, Монгол улсын стандартчиллын тогтолцоо. 2-р хэсэг: Стандартын бүтэц ба боловсруулах дүрэм” стандартад нийцүүлсэн.

Уг стандартыг Хүүхдийн хөгжил, хамгааллын техникийн хорооны хурлаар хэлэлцэж дэмжсэн болно.

**Стандарт, хэмжил зүйн газар (СХЗГ)**  
**Энхтайваны өргөн чөлөө 46А**  
**Улаанбаатар 13343, Ш/Х - 48**

**Утас: 263860, 262201**  
**Факс (976-11) 458032**  
**E-mail: [standardinform@masm.gov.mn](mailto:standardinform@masm.gov.mn),**  
**[www.masm.gov.mn](http://www.masm.gov.mn), [www.estandart.gov.mn](http://www.estandart.gov.mn)**  
**© СХЗГ 2023**

“Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай” хуулийн дагуу энэхүү стандартыг бүрэн эсвэл хэсэгчлэн хэвлэх, олшруулах эрх нь гагцхүү СХЗГ (Стандартчиллын төв байгууллага)-д байна.

## МОНГОЛ УЛСЫН СТАНДАРТ

Ангилалтын код 03.080.30

Хүүхдийн зуслангийн үйл ажиллагаа. Ерөнхий шаардлага	MNS 5633:2023
Childrens camp activities. General requirements	MNS 5633:2019-ийн оронд

Стандарт, хэмжил зүйн газрын даргын 2023 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн С/28 дугаар тушаалаар батлав.

Энэ стандарт нь 2023 оны 06 дугаар сарын 30-ны өдрөөс эхлэн хүчинтэй.

### 1 Зорилго

Энэхүү стандартын зорилго нь Монгол Улсын нутаг дэвсгэр дээр хүүхдийн зуслангийн үйл ажиллагаанд тавих дараах нийтлэг шаардлагыг тогтоож, мөрдүүлэхэд оршино. Үүнд:

- Хүүхдийн хөгжил, хамгаалал, оролцоог хангасан, хүүхдэд ээлтэй хөгжлийн орчин бүрдүүлэх;
- Хүүхдийн хөгжлийн хэрэгцээнд нийцэхүйц, хүүхэд бүрийн оролцоог хангасан мэдлэг, чадвар, хандлага төрүүлэхэд чиглэсэн бүтээлч зорилго чиглэл бүхий хөгжлийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх;
- Эрсдэлээс урьдчилан сэргийлэх, эрүүл хоол хүнс, аюулгүй тээврийн хэрэгслээр үйлчлэх;
- Хүүхдийн зусланд мэргэшсэн хүний нөөц ажиллуулах.

### 2 Хамрах ба хэрэглэх хүрээ

Энэхүү стандартыг Монгол Улсын нутаг дэвсгэр дээр хүүхдийн зуслангийн үйл ажиллагаа эрхэлж, үйлчилгээ үзүүлдэг өмчийн бүх хэлбэрийн зуслангийн үйл ажиллагааг төлөвлөх, хэрэгжүүлэх, зохион байгуулах, үйлчилгээний явц, чанар, болон хүүхдийн хөгжил, оролцоо, хамгаалалд хяналт тавих, үнэлэхэд хэрэглэнэ.

### 3 Норматив эшлэл

Энэхүү стандартын зарчим, үзэл баримтлал нь олон улсын болон үндэсний хэмжээнд хүүхдийн эрх, хамгааллын талаар баримталж буй бодлогын баримт бичигт суурилсан бөгөөд эдгээрийг нэгэн адил дагаж мөрдөнө. Уг стандартад норматив эшлэл болгон дурдсан дараах баримт бичигт өөрчлөлт орсон тохиолдолд эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем болон албан ёсны эх материалыг баримтална. Үүнд:

MNS 5390, Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй,

MNS 4968, Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй. Үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд тавих ерөнхий шаардлага,

MNS 4996, Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй. Ажлын байрны гэрэлтүүлгийн норм, хэмжих аргад тавих ерөнхий шаардлага,

MNS ISO 8124-4, Тоглоомын аюулгүй байдал,

MNS 0884, Модон тоглоом,

MNS 3473, Байгаль хамгаалал. Газар. Газар эдэлбэр. Газар ашиглалт. Нэр томъёо, тодорхойлолт,

MNS 4621, Эрүүл мэндийг хамгаалах технологи. Эмчилгээ оношилгооны түгээмэл үйлдлүүд,

MNS 4968, Эрүүл ахуй. Ерөнхий шаардлага,

MNS 5924, Нүхэн жорлон, угаадасны нүх. Техникийн шаардлага,

MNS 4244, Галын аюулгүй байдал. Ерөнхий шаардлага,

MNS 5247, Барилга, байгууламжийн гал унтраах, ус түгээгүүрийн цогцолбор,

## **MNS 5633:2023**

MNS 5566, *Аж ахуйн нэгж, байгууллага, барилга байгууламжид гал унтраах анхан шатны багаж хэрэгслийн зайлшгүй байх шаардлага, норм,*  
MNS 5150, *Хөдөлмөрийн аюулгүй байдал. Үйлдвэрлэлийн эрүүл ахуй. Цахилгааны аюулгүй ажиллагаа. Ерөнхий шаардлага,*  
MNS 0900, *Хүрээлэн буй орчин. Эрүүл мэндийг хамгаалах. Аюулгүй байдал. Ундны ус. Эрүүл ахуйн шаардлага, чанар, аюулгүй байдлын үнэлгээ,*  
MNS 6279, *Ус хангамж, ариун цэврийн байгууламж. Нэр томьёо, тодорхойлолт,*  
MNS SAC/RCP 39, *Нийтээр нь үйлчлэх хоол үйлдвэрлэл, үйлчилгээнд мөрдөх эрүүл ахуйн дадал зэрэглэл. Үндсэн шаардлага,*  
MNS 4946, *Хоолны газрын ангилал, зэрэглэл. Үндсэн шаардлага,*  
MNS 4958, *Амралт, сувиллын газрын үйлчилгээ,*  
MNS 5163, *Халуун усны үйлчилгээ. Ерөнхий техникийн шаардлага,*  
MNS 4588, *Хэрэглэгчдэд зориулсан үйлчилгээ. Зочид буудалд тавих ерөнхий шаардлага,*  
MNS 5161-3, *Ахуйн шавж, мэрэгч устгах, халдваргүйжүүлэлт. 3-р хэсэг: Үйлчилгээ,*  
MNS 5344, *Ахуйн хог хаягдлыг тээвэрлэхэд тавих ерөнхий шаардлага,*  
MNS 6440, *Хүүхэд тээвэрлэх автобус. Автобус ба үйлчилгээнд тавих шаардлага,*  
MNS 6593, *Авто тээврийн хэрэгслээр ачаа, зорчигч тээвэрлэлт. Нэр томьёо, тодорхойлолт,*  
MNS 4598, *Авто тээврийн хэрэгслийн техникийн байдалд тавих ерөнхий шаардлага,*  
MNS 5682, *Явган хүн, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан зам. Техникийн шаардлага,*  
MNS 6055, *Иргэний барилгын төлөвлөлтөд хөгжлийн бэрхшээлтэй хүний шаардлагыг тооцсон орон зай, орчин,*  
MNS 6751, *Хүүхдийн тоглоомын талбай. Техникийн ерөнхий шаардлага,*  
MNS 6264, *Үндэсний морин уралдааны морь унаач хүүхдийн хамгаалалтын хувцас, морины хэрэгсэлд тавих шаардлага,*  
БНБД 31-03-03\*/11, *Олон нийт, иргэний барилга,*  
БНБД 30.01.04, *Хот тосгоны төлөвлөлт, барилгажилтын норм ба дүрэм,*  
БНБД 23-02-08, *Байгалийн гэрэлтүүлэг ба зохиомол гэрэлтүүлэг,*  
БНБД 21-01-02, *Барилга байгууламжийн галын аюулгүй байдал,*

### **4 Нэр томьёо, тодорхойлолт**

Энэхүү стандартад хэрэглэсэн нэр, томьёог дор дурдсан утгаар ойлгоно.

#### **4.1**

##### **хүүхэд**

төрсөн цагаас нь эхлэн 18 нас хүрээгүй хүн бүр<sup>1</sup>

#### **4.2**

##### **хүүхдийн зуслан**

үзэсгэлэнт байгаль, цэвэр орчинд байрласан, олон улс, үндэстний хүүхэд, өсвөр үе, залуучуудын эрхийг дээдэлсэн, тэдний амрах, хөгжих, оролцох, чөлөөт цагаа зөв зохистой өнгөрүүлэх хөгжлийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх, хүүхдэд ээлтэй, аюулгүй ногоон орчныг бүрдүүлсэн үйлчилгээний байгууллага

#### **4.3**

##### **амьдрах ухаан, хөдөлмөрийн дадал олгох зуслан**

<sup>1</sup> НҮБ, Хүүхдийн Эрхийн Конвенц, 1990



хүүхдийн чөлөөт цагийг зөв зохистой өнгөрүүлж, төлөвшүүлэх, мэргэжил сонголтоо хийхэд туслах, хөдөлмөрийн дадал олгох, аюулгүй байдал, осол гэмтлээс сэргийлэх мэдлэг олгох хөтөлбөрийг хэрэгжүүлэх, хүүхдэд ээлтэй, аюулгүй орчныг бүрдүүлсэн үйлчилгээний байгууллага

#### 4.4

##### **нүүдлийн соёлын зуслан**

нүүдлийн ахуйд суурилсан соёлын өвийн тухай мэдлэг, мэдээллээр хангах зорилго бүхий хөтөлбөрийг хэрэгжүүлэх, хүүхдэд ээлтэй, аюулгүй орчныг бүрдүүлсэн үйлчилгээний байгууллага

#### 4.5

##### **соёлын биет бус өвийг өвлөн уламжлагч**

Монгол соёлын өв болон нүүдлийн аж ахуйн мэдлэг, малч ухааныг өвлөн уламжлагч

#### 4.6

##### **хөгжлийн хөтөлбөр**

хүүхдийн хөгжлийн хэрэгцээ, оролцоонд суурилсан зорилго, зорилт, агуулга, аргачлал, орчин, хэрэглэгдэхүүнийг тодорхойлсон баримт бичиг

#### 4.7

##### **хөгжлийн хөтөлбөрийн хэрэглэгдэхүүн**

хөгжлийн хөтөлбөрийн хэрэглэгдэхүүнд хүүхдийн насны онцлогт тохирсон спорт тоглоомын, хөгжмийн зэмсэг, техник хэрэгсэл, сургалтын материал, гадаад орчны, сургалтын, аяллын хэрэгслүүд

#### 4.8

##### **хүүхдийн хөгжлийн жишиг хөтөлбөр**

хүүхдийн ялгаатай байдалд суурилсан, хүүхэд өсвөр үеийнхний өөрийн ухамсар, харилцааны ур чадвар, хариуцлагатай шийдвэр гаргах болон бусад чадвар, чадамжуудыг хөгжүүлж, дэмжих зорилготой Хүүхдийн хөгжлийн жишиг хөтөлбөр<sup>2</sup>

#### 4.9

##### **хүүхэд хамгаалал**

хүүхэд бүрийг нийгмийн бүхий л орчинд аливаа дарамт, хүчирхийлэл, мөлжлөг, үл хайхрах явдлаас хамгаалах<sup>3</sup>

#### 4.10

##### **хүүхдийн оролцоо**

хүүхэд бүр мэдээлэл олж авах, өөрийгөө хөгжүүлэн хамгаалах, санаа бодлоо илэрхийлэх, дуу хоолойгоо хүргэх, гэр бүл, сургууль, олон нийтийн бүхий л орчинд өөрт хамаатай шийдвэр гаргахад хариуцлагатай оролцсоноор нийгмийн хөгжилд хувь нэмрээ оруулан, сайн сайхан хөгжлийг дэмжих байгууллага, хөдөлгөөн үүсгэх, нэгдэн орох эрх эдлэх<sup>4</sup>

<sup>2</sup> Хүүхдийн хөгжлийн жишиг хөтөлбөр, УБ 2019

<sup>3</sup> Хүүхэд хамгааллын тухай хууль, 2016

<sup>4</sup> Хүүхдийн асрамж, халамж, хамгааллын үйлчилгээнд тавих нийтлэг шаардлага

## **MNS 5633:2023**

### **4.11**

#### **авьяас**

үйл ажиллагааг эзэмших, амжилттай гүйцэтгэхэд нөлөөлж буй сэтгэл зүйн, хувийн болон нийтлэг онцлог шинж чанар

### **4.12**

#### **чадвар**

сургалт болон тодорхой туршлагын үр дүнд бий болох аливаа зүйлийг хийж гүйцэтгэх эв дүй, зан үйл, дадал

### **4.13**

#### **хандлага**

хувь хүн ба бүлгийн сонирхол, үнэт зүйлс, үзэл бодол, итгэл үнэмшлийн илрэл бөгөөд

тухайн нөхцөлд үнэт зүйлсийг баримжаа болгон үзүүлж байгаа эерэг ба сөрөг хариу үйлдэл

### **4.14**

#### **чадавх**

хөгжлийн хөтөлбөрийн хүрээнд олгож буй мэдлэг-мэдээллийг тусгаж хүлээн авах хувь хүний нөөц боломж

### **4.15**

#### **чадамж**

аливааг амжилттай гүйцэтгэхэд шаардагдах мэдлэг, чадвар, хандлагын нэгдэл  
ТАЙЛБАР: Хөгжлийн хөтөлбөрт хамрагдсан хүүхдийн хөгжлийн чанарыг илтгэх гол үзүүлэлтийн нэг.

### **4.16**

#### **арга зүй**

арга судлал буюу бүлгийн ажил, үйл ажиллагааг сонгон хэрэгжүүлэх, зохион байгуулах үндэслэлийг тодорхойлсон тулгуур зарчмуудын нэгдэл

### **4.17**

#### **хөгжлийн хөтөлбөрийн холимог хэлбэр**

хүүхдийн сонирхол хэрэгцээнд тулгуурласан хоёр болон түүнээс дээш чиглэлийг төлөвлөж боловсруулсан хөгжлийн хөтөлбөр

### **4.18**

#### **хөгжлийн хөтөлбөрийн төрөлжсөн хэлбэр**

тухайн нэг чиглэлээр дагнан боловсруулсан хөгжлийн хөтөлбөр

## **5 Үйл ажиллагааны чиглэл**

**5.1** Зуслангийн газар зүйн байршил, хүүхдийн хэрэгцээ, үйл ажиллагааны онцлогоос хамааран хүүхдийн зуслан нь дараах чиглэлээр үйл ажиллагаа явуулж болно.

**5.1.1** Хүүхдийн зуслан

**5.1.2** Гэр бүл-хүүхдийн зуслан

**5.1.3** Төрөлжсөн сургалтын зуслан

**5.1.4** Амьдрах ухаан, хөдөлмөрийн дадал олгох зуслан

**5.1.5** Нүүдлийн соёлын зуслан

**5.2** Зуслан өөрийн онцлогт тохируулан үйл ажиллагааны чиглэлийг төрөлжсөн болон холимог хэлбэрээр төлөвлөж, зохион байгуулна.

## **6 Ерөнхий шаардлага**

**6.1 Хүүхдийн зуслангийн чиглэлээр үйл ажиллагаа эрхэлж, үйлчилгээ үзүүлэх байгууллагад тавих ерөнхий шаардлага**

**6.1.1** Хүүхдийн зуслангийн үйл ажиллагаа эрхлэх байгууллага нь Монгол улсад бүртгэлтэй, хүүхдийн зуслангийн стандартын тохирлын баталгаанд заавал хамрагдсан, тухайн жилд хүүхдийн зуслангийн үйл ажиллагааг эрхлэх холбогдох мэргэжлийн байгууллагын дүгнэлттэй байна.

**6.1.2** Үйлчилгээг хүргэх зориулалт бүхий орчин нөхцөлийг бүрдүүлсэн өөрийн өмчийн болон эзэмшлийн газар байртай байна.

**6.1.3** Хүүхдийн зуслан нь Хөдөлмөрийн тухай хуулийг хэрэгжүүлэгч байж, хүний нөөцөд болон ажлын байранд тавих шаардлагын хүрээнд ажилтан, албан хаагчдын мэргэжлийн мэдлэг, чадварыг хөгжүүлэх хөтөлбөртэй байна.

**6.1.4** Үйлчилгээний журам, багш, ажилтнуудын баримтлах ёс зүйн дүрэм болон хүүхэд хамгааллын бодлогын баримт бичиг, үйл ажиллагааны журам, зааварчилгаатай байна.

**6.1.5** Хүүхдийн зусланг хүүхдийн, боловсролын байгууллагад 3-аас доошгүй жил ажилласан, бакалавр болон түүнээс дээш зэрэгтэй, удирдан зохион байгуулах ур чадвартай удирдлагын баг удирдана.

**6.1.6** Удирдлагын баг нь үйл ажиллагааг зохион байгуулах хэтийн зорилго, ажлын төлөвлөлттэй байна.

**6.1.7** Зуслан өөрийн онцлог, үйл ажиллагааны чиглэлд тохирсон Хөгжлийн хөтөлбөр боловсруулан удирдлагын багаар хэлэлцүүлж, баталгаажуулна.

**6.1.8** Хүүхдийн хөгжлийн хөтөлбөр хэрэгжүүлэхэд шаардлагатай орчин, нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор санхүүгийн хувьд түшиглэсэн байгууллагатай байж болно.

## **6.2 Хүний нөөцөд тавих ерөнхий шаардлага**

**6.2.1** Хүүхдийн зуслангийн үйл ажиллагаа эрхлэх байгууллагын удирдлагын баг болон ажилтнуудын 90-ээс доошгүй хувь нь Монгол Улсын иргэн байна.

**6.2.2** Хүүхдийн зуслан нь эмч, үйл ажиллагааны чиглэлд тохирсон багш, соёлын биет бус өвийг өвлөн уламжлагч, ажилтантай байна.

**6.2.3** Зуслангийн багш, ажилтан, албан хаагчид нь эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг, шинжилгээнд заавал хамрагдана.

**6.2.4** Багш, ажилтан, албан хаагчид нь мэргэжлийн байгууллагаар биеийн болон сэтгэцийн эрүүл мэндийн хувьд эрүүл гэдгээ тогтоолгоно.

**6.2.5** Зусланд ажиллагсад нь эрүүгийн хариуцлага, гэмт хэрэг, зөрчилд холбогдож байгаагүйг Цагдаагийн төв байгууллагын мэдээллийн сангийн "Тодорхойлолт"-оор нотолно.

**6.2.6** Хүүхдийн зусланд ажиллах багш, ажилтан, соёлын биет бус өвийг өвлөн уламжлагч, албан хаагчид нь хүүхдийн хөгжил, эрх, хамгаалал, эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээ үзүүлэх, хүүхэдтэй ажиллах, төлөвшүүлэх чиглэлээр эрх бүхий байгууллагаас тухайн жилд зохион байгуулсан сургалтад хамрагдаж, гэрчилгээгээр баталгаажсан байна.

**6.2.7** Багш, ажилтан, албан хаагчид нь хүүхэдтэй ажиллах, хүүхдэд үйлчилгээ үзүүлэх мэргэжлийн мэдлэг, ур чадвартай, мэргэшсэн байна.

**6.2.8** Хоол үйлдвэрлэл, үйлчилгээг эрхлэх ажилтан нь мэргэжлийн, мэргэшсэн байна.

**6.2.9** Хөгжлийн хөтөлбөрийг боловсруулах, хэрэгжүүлэх, үнэлэх мэдлэг, чадвар бүхий мэргэшсэн арга зүйч, багштай байна.



## **MNS 5633:2023**

**6.2.10** Биеийн тамир, спортын болон хүүхдийн хөгжил, оролцоог дэмжих чиглэлээр багшлах мэргэжлийн арга зүйч багштай байна.

**6.2.11** Хүүхдийн зусланд ажиллах бүлгийн багш нь хүүхдийн нас, бие, сэтгэл зүйн онцлогийн талаар мэдлэгтэй, 21-ээс доошгүй настай байна.

**6.2.12** Тухайн зуслан нь туслах багш, соёлын биет бус өвийг өвлөн уламжлагчийг ажиллуулах бол Хөдөлмөрийн гэрээнд эрх, үүрэг, хариуцлагыг тодорхой зааж, түүнд нь тохирсон цалин хөлсийг тусгаж, мөрдөнө.

## **7 Хүүхдийн зуслангийн хоол үйлдвэрлэл үйлчилгээ**

**7.1** Хоол үйлдвэрлэл, үйлчилгээг эрхлэхэд “MNS 4946, Хоолны газрын ангилал, зэрэглэл. Ерөнхий шаардлага” стандартын үндсэн шаардлагыг хангана.

### **7.2 Хоол үйлдвэрлэлийн үйл ажиллагааны эрүүл ахуй, аюулгүй байдал**

**7.2.1** Хүүхдийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний эрүүл ахуйн дадал нь “MNS SAC /RCP 39, Нийтээр нь үйлчлэх хоол үйлдвэрлэл, үйлчилгээнд мөрдөх эрүүл ахуйн дадал зэрэглэл. Үндсэн шаардлага” стандартад нийцсэн байна.

**7.2.2** Хүүхдийн хоол үйлдвэрлэлд хэрэглэж байгаа хүнсний бүтээгдэхүүн нь чанар, эрүүл ахуйн аюулгүйн баталгаажуулалтад хамрагдсан, шинжилгээ дүгнэлттэй байна.

**7.2.3** Хоол үйлдвэрлэлийн үйл ажиллагаа, хэрэглэж байгаа сав, хэрэгсэл тоног төхөөрөмж нь хүний биед хор нөлөөгүй, эрүүл ахуйн шаардлагыг хангасан байна.

**7.2.4** Хоол, хүнсний бүтээгдэхүүнийг зориулалтын тээврийн хэрэгслээр тээвэрлэнэ.

**7.2.5** Хүнсний бүтээгдэхүүний хадгалалт нь эрх бүхий байгууллагаас баталсан, хүчин төгөлдөр мөрдөгдөж буй дүрэм, журмыг мөрдөж, зориулалтын тээврийн хэрэгслээр тээвэрлэх, бүтээгдэхүүний хадгалалтын горимыг баримталж ажиллана.

**7.2.6** Хүүхдийн хоол, хүнсээр авбал зохих илчлэг, шимт бодисын хэмжээг хангахуйцаар тооцож, баталсан цэсийн дагуу хоол үйлдвэрлэлийн үйл ажиллагааг явуулна.

**7.2.7** Хүүхдийн аяллын хоолыг бэлтгэхдээ түргэн муудахгүй хүнсний бүтээгдэхүүнийг сонгож, савлагаа, хадгалах орчин, нөхцөлийг бүрдүүлнэ.

**7.2.8** Аяга, таваг, халбага, сэрээ нь 1 суудалд 2 ээлж байхаар төлөвлөн, аяга, таваг угааж, ариутгах төхөөрөмжөөр хангасан байна.

**7.2.9** Хүнсний гаралтай халдвар, хордлого гарах эрсдэлийг дотооддоо хянан бүртгэж, залруулах арга хэмжээ авч ажиллана.

**7.3** Ажилтнуудад хоол хүнсийг бохирдлоос сэргийлэх, хүнсний эрүүл ахуйн сургалт сурталчилгааг тогтмол зохион байгуулж, хүүхдэд эрүүл ахуйн зохистой дадал эзэмшүүлэх чиглэлээр хамтран ажиллана.

**7.4** Цэвэрлэгээ, халдваргүйжүүлэлтийн бодисыг зориулалтын дагуу зөв найруулж, ашиглан, найруулсан огноог бичиж хэрэглэнэ.

**7.5** Зөөврийн ундны ус нөөцлөх савыг 3 хоног тутамд угааж, ариутгана.

**7.6** Хүүхдийн цэвэр ус уух боломжийг бүрдүүлнэ.

## **8 Хүүхэд тээвэрлэх үйлчилгээ**

**8.1** Хүүхдийг зусланд ирэх болон буцахад Монгол улсын замын хөдөлгөөний дүрмийг баримтлан MNS 6440 стандартын бүх шаардлага болон MNS 4598 стандартын 8 дугаар зүйлд заасан шаардлагыг хангасан тээврийн хэрэгслээр үйлчилнэ.



## **8.2 Тээврийн үйлчилгээний зохион байгуулалт**

**8.2.1** Зуслангийн захиргаа, тухайн орон нутгийн тээвэр, авто замын газартай байгуулсан гэрээ, батлагдсан маршрутын дагуу хүүхэд тээвэрлэнэ.

**8.2.2** Хүүхэд тээвэрлэх үйл ажиллагааг цувааны ахлагч (зуслангийн захирал, ахлах удирдагч, хамгаалалтын хэсгийн дарга, замын цагдаа) зохион байгуулж ажиллана.

**8.2.3** Хүүхдийг аюулгүй тээвэрлэхийг жолооч, тээврийн хэрэгсэл доторх хүүхдийн зохион байгуулалтыг бүлгийн багш хариуцна.

**8.2.4** Цувааны ахлагч нэг тээврийн хэрэгсэлд суух хүүхдийн тоог тогтоож, нас, биеийн онцлогийг харгалзан хуваарилалтыг хийнэ.

**8.2.5** Жолооч болон бүлгийн багш хуваарилалтын дагуу хүүхэд бүрийг тээврийн хэрэгслийн суудалд суулгаж, хамгаалалтын бүс хэрэглүүлэх ба ачаа тээшийг зориулалтын саванд эсвэл хүүхдийн аюулгүй байдалд саад учруулахгүйгээр байрлуулна.

**8.2.6** Зорчигч хүүхэд тээвэрлэлтийн үед гэнэт өвдсөн, гэмтсэн тохиолдолд анхан шатны тусламж үзүүлж, эмнэлэгт яаралтай хүргэх арга хэмжээ авна.

**8.2.7** Тээврийн хэрэгслүүд цуваагаар явах журмыг баримтална.

**8.2.8** Хүүхэд цуваанаас хоцрохоос сэргийлж, цуваа хөдлөх тухай сануулгыг зарлана.

**8.2.9** Цуваа нь тогтсон цагт, хуваарийн дагуу цувааны ахлагчийн заавраар хөдөлгөөнийг эхэлнэ.

**8.2.10** Хүүхэд тээвэрлэх явцад гаднын зорчигч суулгах, ачаа ачихыг хориглоно.

## **8.3 Хөдөлгөөний хяналт, тээвэрлэлтийн үйлчилгээний эргэх холбоо**

**8.3.1** Хүүхэд тээвэрлэх үед хөдөлгөөний хяналтыг урьдчилан тогтоож, баталгаажуулна.

**8.3.2** Хүүхэд тээвэрлэж буй тээврийн хэрэгсэл нь хөдөлгөөнд оролцохдоо Монгол Улсын Замын хөдөлгөөний дүрмийн заалтын дагуу 50 км/ц-ийн хурдтай явна.

**8.3.3** Олон нийт, үзвэр үйлчилгээ, түүх соёлын газруудаар явах тохиолдолд явах замын маршрут гаргаж, батлан мөрдөнө.

**8.3.4** Цуваа ирэхийн өмнө талбайг чөлөөлж, машин тавих бэлтгэлийг хангаж, автобусыг хүүхэд бууж, суухад саад болохгүйгээр байрлуулна.

**8.3.5** Зуслангийн эзэмшил газрын бүсэд автомашины зогсоолыг тогтоож, тэмдэгжүүлнэ.

**8.3.6** Давагдашгүй хүчин зүйлийн нөхцөл байдлаас болон авто замын хөдөлгөөний түгжрэл, автомашины эвдрэл гэмтэл, жолооч, зорчигч хүүхдийн эрүүл мэнд зэргээс шалтгаалан хүүхэд зөөвөрлөж яваа тээврийн хэрэгсэл очих цагаасаа хоцрох тохиолдолд хүлээн авагч талд албан ёсоор мэдэгдэнэ.

## **9 Хүүхдийн зуслангийн эрүүл мэндийн үйлчилгээ**

### **9.1 Эрүүл мэндийн үйлчилгээ**

**9.1.1** Эмч нь хүүхэд амрах, чийрэгжих, эрүүл аюулгүй орчин бүрдүүлэхэд хяналт тавьж ажиллана.

**9.1.2** Шаардлагатай тохиолдолд эмч амрагч хүүхдийг урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулж, анхны болон яаралтай тусламж, үйлчилгээг үзүүлнэ.

**9.1.3** Эмнэлгийн тусламж үйлчилгээнд чанарын баталгаатай эм, тариа, боолтын материал хэрэглэнэ. Шаардагдах нөөцийг бүрдүүлсэн байна.

**9.1.4** Зусланд амрах эрхийн бичгийн эмнэлгийн тодорхойлолтод тухайн хүүхэд эмчийн үзлэгт хамрагдсан, шээс (цөсний пигмент), цагаан хорхой, сүрьеэгийн шинжилгээ өгч, эрүүл мэнд хувьд тэнцсэн дүгнэлтийг мэргэжлийн эмч эсхүл эмнэлгийн байгууллагаар гаргуулан тамга, тэмдгээр баталгаажуулсан тохиолдолд хүлээн авна.

## **MNS 5633:2023**

**9.1.5** Эмнэлгийн тодорхойлолтод тухайн хүүхдэд харшилдаг эм тариа, хоол хүнс, ургамал, амьтан байдаг эсэх тэмдэглэл хийлгэсэн байна.

**9.1.6** Тухайн хүүхэд нь эмийн болон хоолны эмчилгээтэй тохиолдолд хяналтын эмчийн зөвшөөрөлтэй байна.

**9.1.7** Хүүхдийг аялалд явахын өмнө эмч үзлэг хийж, зөвлөгөө өгсөн байна.

**9.1.8** Гамшиг, осол гэмтлийн үед яаралтай тусламж үзүүлэх нөхцөлийг бүрдүүлнэ.

### **9.2 Хүүхдэд үзүүлэх эмнэлгийн анхны тусламж, үйлчилгээ**

**9.2.1** Хүүхэд өвдсөн тохиолдолд эмч яаралтай тусламж үзүүлж, тусламж үзүүлсэн тухай тэмдэглэл хөтөлнө.

**9.2.2** Эмнэлэгт хүргэх шаардлагатай тохиолдолд яаралтай тусламжийн дуудлага өгч, эмч, бүлгийн багш хамт хүргэнэ.

**9.2.3** Хүүхдийн өвчлөлийн тухай эцэг эх, асран хамгаалагчид заавал мэдэгдэж цаашдын эмчилгээний зөвшөөрлийг авна.

**9.2.4** Хүүхэд эмнэлэгт хэвтэж эмчлүүлэх шаардлагатай бол эцэг эх, асран хамгаалагчийн асрамжид үлдээнэ.

### **9.3 Хүүхдэд эрүүл ахуйн дадал, чадвар олгох үйлчилгээ**

**9.3.1** Осол гэмтэл, өвчлөлөөс өөрийгөө хамгаалах, анхан шатны тусламж үзүүлэх талаар насны онцлогт тохирсон эрүүл мэндийн мэдээлэл, сурталчилгаа, сургалтыг төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу тогтмол зохион байгуулна.

**9.3.2** Өсвөр насны хүүхдэд нөхөн үржихүйн эрүүл мэндийн болон хорт зуршлаас урьдчилан сэргийлэх талаар мэдлэг, мэдээлэл өгөх ажлыг тогтмол зохион байгуулна.

**9.3.3** Хүүхдэд эрүүл мэндийн болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх мэдээлэл, мэдлэг, чадвар олгох чиглэлээр багш, ажилтантай хамтран ажиллах төлөвлөгөө боловсруулж, хэрэгжүүлнэ.

**9.3.4** Хүүхдэд эрүүл мэндийн анхны тусламж үзүүлэх арга, чадвар олгоно.

## **10 Хүүхдийн хөгжлийн хөтөлбөр**

**10.1** Зуслан газар зүйн байршил, үйл ажиллагааныхаа чиглэл, онцлогт тохирсон, хүүхдийн хөгжлийн хэрэгцээ, оролцоог хангасан бүтээлч зорилго чиглэл бүхий хөгжлийн баримт бичигтэй байна.

**10.1.1** Хүүхдийн зуслангийн хөгжлийн хөтөлбөр нь хүүхдийн ялгаатай байдалд суурилсан Хүүхдийн хөгжлийн жишиг хөтөлбөртэй нийцсэн байна.

**10.1.2** Хөгжлийн хөтөлбөр нь хүүхдийн бодит хэрэгцээнд нийцсэн, шинжлэх ухааны үндэслэлтэй ойлголт, мэдлэг, чадварыг эзэмшүүлэхэд чиглэсэн бүтээлч үйл ажиллагаа байна.

**10.1.3** Зуслан сонгосон хөгжлийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөө, удирдамж боловсруулж, баталгаажуулан, хэрэгжилтэд тогтмол дүн шинжилгээ хийнэ.

**10.1.4** Хөгжлийн хөтөлбөрийн агуулга, арга зүйг хүүхдийн санал, сэтгэл ханамжийн судалгаан дээр тулгуурлан жил бүр шинэчлэн боловсруулна.

**10.1.5** Хөгжлийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх, аюулгүй орчин, нөхцөлийг бүрдүүлсэн, шаардлагатай материал, хэрэгслээр хангасан, нөөцтэй байна.

**10.1.6** Хөгжлийн хөтөлбөрийн хэрэгжилтийг жил бүр дүгнэж, агуулга, арга зүй орчин нөхцөлийг тогтмол сайжруулна.

**10.1.7** Хөгжлийн хөтөлбөрийн хэрэгсэл нь хүүхдийн эрүүл мэндэд хор учруулахгүй материалаар хийсэн, Олон улсын болон Монгол Улсын стандартын шаардлагыг хангасан байхаас гадна хэрэгслийн бүртгэл үйлдэж, ашиглалтын тэмдэглэл хөтөлнө.

**10.2 Хөгжлийн хөтөлбөрийн зорилго**

Хүүхэд өсвөр үеийнхний өөртөө итгэлтэй, бие бялдар, оюун сэтгэхүй, ёс суртахууны төлөвшил, харилцааны болон хариуцлагатай, хамтач байх, шийдвэр гаргах чадвартай, бүтээлч, санаачилгатай хувь хүн болон хөгжихөд дэмжлэг үзүүлнэ.

**10.3 Хөгжлийн хөтөлбөрийн зорилт**

Хөгжлийн хөтөлбөр нь хүүхэд, өсвөр үеийнхнийг хөгжүүлэх, чадвар эзэмшүүлэх, хандлага төлөвшүүлэхэд чиглэсэн агуулгатай байна. Үүнд:

**10.3.1** Эх орныхоо түүх соёл, үндэсний уламжлалаас суралцах, тэдгээрт хүндэтгэлтэй ханддаг байх,

**10.3.2** Хүүхэд өөрийгөө илэрхийлэх, өөртөө итгэлтэй, аливааг тунгаан бодох, шийдвэр гаргах чадварыг хөгжүүлэх,

**10.3.3** Байгаль орчноо хайрлах, уур, амьсгалын өөрчлөлт, түүний учир шалтгаан, зүй тогтлыг судалж танин мэдэх,

**10.3.4** Эрүүл аж төрөх, хорт зуршлаас урьдчилан сэргийлэх, цахим орчны зохистой хэрэглээ, зэрэг зан үйлийг дэмжих,

**10.3.5** Бусдын ялгаатай байдлыг мэдэрч ойлгох, тэдэнд хүндэтгэлтэй, чин сэтгэлээсээ хандаж хамтран ажилладаг, үе тэнгийнхний дээрэлхэлт, дарамтаас урьдчилан сэргийлдэг байх.

**10.4 Хөгжлийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх ерөнхий шаардлага**

Хөгжлийн хөтөлбөрийг хүүхэд бүрийн оролцоонд тулгуурлан, нас, бие, сэтгэхүйн онцлог, сонирхол хэрэгцээнд нийцүүлэн, урьдчилан бэлтгэл хангасан орчинд дараах зарчмыг баримтлан зохион байгуулна. Үүнд:

**10.4.1** Хувь хүний эрүүл эерэг чанар, үнэт зүйлсийг хүндэтгэнэ.

**10.4.2** Хүүхдэд тодорхой үүрэг даалгавар өгөх замаар тэдний итгэлийг сэргээж, үүрэг хариуцлагыг нэмэгдүүлнэ.

**10.4.3** Хүүхдийн хувь хүний үнэлэмж нь нийгмийн үнэлэмж хэм хэмжээтэй зохицоогүй тохиолдолд үнэт зүйлсийн сөргөлдөөн гарахаас сэргийлнэ.

**10.4.4** Хүүхдэд өөрсдийн төсөөлөл, сэтгэгдэл, туршлагаа хуваалцах сонирхлыг бий болгохуйц дэмжсэн, хүлээн зөвшөөрсөн мэдрэмж төрөхөөр нээлттэй, шударга, хүндлэлтэй харилцах уур амьсгал, орчин бий болгоно.

**10.4.5** Хүүхэд бүрд оролцох, хөгжих тэгш боломжийг олгоно.

**10.5 Хөгжлийн хөтөлбөрийн хэлбэр**

Хүүхдийн зуслангийн хөгжлийн хөтөлбөрийг төрөлжсөн болон холимог хэлбэрээр, танхимд болон байгаль түшиглэн зохион байгуулна.

**10.6 Хөгжлийн хөтөлбөрийн чиглэл**

**10.6.1** Хүүхдийн давуу чанарт суурилсан хөгжлийн хөтөлбөр нь хүүхдэд танин мэдэх, нийгэмшихүйн чадвар, чадамжуудыг олгох, хандлага төлөвшүүлэх, хүүхдийн оролцооны зарчимд тулгуурласан мэдээлэл олгох, хөгжүүлэх чиглэлтэй байна.

**10.6.2** Хөгжлийн хөтөлбөрийн жишиг чиглэл:



Хөгжлийн хөтөлбөрийн хэлбэр	Хөтөлбөрийн чиглэл
Хүүхэд-гэр бүлийн хөтөлбөр	Гэр бүлийн боловсрол, угийн бичиг, гэр бүлийн үнэ цэнэ, үнэлэмж, гэр бүлийн төлөвшил, бахархлыг төрүүлэх гэх мэт гэр бүлийн зэрэг харилцааг дэмжих
Хувь хүний хөгжлийн хөтөлбөр	Өөрийгөө илэрхийлэх, хөгжүүлэх, илтгэх, бусадтай харилцах, хэрхэн сонголт хийх, шийдвэр гаргах ур чадварт суралцах гэх мэт хүүхдийн чадварыг хөгжүүлэх
Амьдрах ухаан, хөдөлмөрийн дадал олгох хөтөлбөр	Мэргэжил сонголт, хөдөлмөрт бэлтгэх, дадал олгох, хөдөлмөрийн аюулгүй байдал, осол гэмтлээс сэргийлэх мэдлэг, ажил мэргэжлийн чиг баримжаа эзэмшүүлэх гэх мэт амьдрах ухааны мэдлэг олгох
Нүүдлийн соёлын хөтөлбөр	Монгол соёл, зан заншилд суралцах, нүүдлийн ахуйтай танилцах, морь унах, цагаан идээ боловсруулах, хадгалах, Монгол тоглоом, наадгай гэх мэт уламжлалт соёлыг түгээн дэлгэрүүлэх, өвлүүлэх
Байгаль орчинд түшиглэсэн хөтөлбөр	Амьтан, ургамлын төрөл зүйлийг танин мэдэх, уур амьсгалын өөрчлөлт, явган аялал гэх мэт хүрээлэн байгаа орчны талаар танин мэдэхүйн мэдлэг олгох
Эрүүл, аюулгүй амьдрах, сэтгэцийн эрүүл мэндийн хөтөлбөр	Хорт зуршлаас урьдчилан сэргийлэх, нөхөн үржихүйн эрүүл мэнд, зөв эрүүл хооллолт, анхны тусламж үзүүлэх, стрессийг даван туулах гэх мэт чадварыг эзэмшүүлэх
Төрөлжсөн сургалтын хөтөлбөр	Шинжлэх ухааны туршилт, хоол хүнс боловсруулах, бэлтгэх, цахим зохистой хэрэглээ, хэл, соёл боловсрол олох гэх мэт хөгжлийг дэмжих
Урлаг, спортын хөтөлбөр	Шүлэг яруу найраг, ардын язгуур урлаг, кино, жүжгийн урлаг, дуу, бүжиг, уран зураг гэх мэт хүүхдийн авьяасыг хөгжүүлэх.
Хүүхдийн эрх, хөгжил оролцоо хамгааллын хөтөлбөр	Хүүхдийн эрх, үе тэнгийнхний дарамт дээрэлхэлтийг зогсоох гэх мэт хүүхдэд эрх зүйн мэдлэг олгох

### 10.7 Хөгжлийн хөтөлбөрийн агуулга

Хөгжлийн хөтөлбөрийн агуулга нь түүх соёл, үндэсний уламжлалаа танин мэдэх, байгаль орчноо хамгаалах, зүй тогтлыг танин мэдэх, өөрийгөө бусдад зөв илэрхийлэх, эрүүл аж төрөх, цахим орчны зохистой хэрэглээ, хорт зуршлаас зайлсхийх, бие даах чадвар эзэмшүүлэх, бусад хүндэтгэлтэй хандаж асуудлыг эерэг аргаар шийдвэрлэх, багаар ажиллах чадвартай хүүхэд, өсвөр үеийнхнийг төлөвшүүлэхэд чиглэнэ. Үүнд:

**10.7.1 Хүүхдийн өөртөө итгэх итгэл, өөрийн үнэлэмжийг дээшлүүлэх:** Хүүхдүүд бие биедээ эерэг үлгэр дуурайлал үзүүлэх, ярилцаж ойлголцох, багш нь хүүхэд бүрд адил тэгш хандан асуудлыг нь ойлгон зөвлөн тусалж, урамшуулдаг харилцааны таатай орчин нөхцөлийг бүрдүүлнэ.

**10.7.2 Хүүхдийн нийгэмшихүйн хөгжлийг чиглүүлж, дэмжих:** Хүүхдийг хөгжүүлэх, идэвхжүүлэх, оролцуулах, хандлагыг төлөвшүүлэн дэмжиж болон буруу зан үйлийг хэвшлийг өөрчилнө.

**10.7.3 Хүүхдийн оролцоог нэмэгдүүлэх:** Хүүхэд бүрийн хүсэл, эрмэлзлийг төрүүлэх сонирхол авьяас чадвараа нээж хөгжүүлэхэд чиглэнэ.

**10.7.4 Хүүхэд стресс, уур бухимдлаа зохицуулах:** Харилцааны зөрчил болон асуудлыг эерэг аргаар шийдвэрлэх чадварт суралцахад чиглэнэ.

**10.7.5 Хүүхдэд алсын хараа, эрхэм зорилгыг талаар ойлголт өгөх:** Хүүхдэд алсын хараа, эрхэм зорилгодоо хүрэх хувийн төлөвлөгөө хийж сурах, хэрэгжүүлэхэд нөлөөлөхөд чиглэнэ.

### 10.8 Хөгжлийн хөтөлбөрийн хэрэглэгдэхүүн

**10.8.1** Хөгжлийн хөтөлбөрийн агуулга, арга зүй, зохион байгуулалтын хэлбэрээс шалтгаалж хэрэглэгдэхүүнийг сонгон хэрэглэнэ. Тухайлбал, спорт тоглоомын, техникийн, аяллын, гадаад орчны болон танин мэдэхүйн сургалтын, морь унаач хүүхдийн хамгаалалтын хувцас хэрэгсэл, хөгжмийн зэмсэг орно.



**10.8.2** Хөгжлийн хөтөлбөрийн хүрээнд зохион байгуулах үйл ажиллагааны онцлогт тохирсон хэрэглэгдэхүүн, хэрэгслийг хүүхэд бүрт хүрэлцэхүйц нөөцтэй бэлтгэсэн байна.

**10.8.3** Хөгжлийн хөтөлбөрийн хэрэглэгдэхүүн, хэрэгсэл нь хүүхдэд эрсдэл учруулахаас байнга сэргийлж, зохих журмын дагуу хадгалж, тэмдэглэл хөтөлнө. Энэ нь урлаг, спорт, байгаль түшиглэсэн хөтөлбөрт илүү хамаарна.

## **11 Хүүхдийн зуслангийн аюулгүй байдал**

**11.1** Хүүхдийн аюулгүй байдлыг хангасан орчин нөхцөлийг бүрдүүлсэн байх бөгөөд осол гэмтлийн үед яаралтай тусламж үзүүлэх нөхцөлийг бүрдүүлнэ.

**11.2** Зуслангийн бүс нутгийн хязгаар, аюулгүй байдлын цэгийг тогтоож, хуулийн дагуу баталгаажуулна.

**11.3** Зуслангийн үйл ажиллагааны чиглэл, хөгжлийн хөтөлбөрийн хэлбэр, онцлогоос хамааран хүүхэд байрлаж амрах байрыг гэр, майхан хэлбэрээр зохион байгуулж болно.

**11.4** Хүүхэд байрлаж амрах гэр нь 5-аас доошгүй ханатай, шалтай байна.

**11.5** Зуслангийн байр, зам, талбай нь тусгай хэрэгцээт хүүхэд амрах, зорчиход саадгүй байхаар тохижуулна.

**11.6** Зуслангийн бүс, барилга хооронд шөнийн гэрэлтүүлэг, камер байрлуулж, эргүүл тогтмол ажиллуулна.

**11.7** Тухайн зуслан нь амрагч хүүхдийн мэдээллээр мэдээллийн сан /архив/ үүсгэж хоёроос доошгүй жил хадгална.

**11.8** Хүүхэд амрах байранд зурагт, Wi-Fi тоног төхөөрөмж байрлуулахгүй бөгөөд хүүхдийн гар утас, интернэт хэрэглээнд хязгаарлалт (өдөрт тогтсон 1-2 цаг интернэт ашиглах боломжийг бүрдүүлнэ) тогтооно.

**11.9** Хүүхдийн ар гэрээс яаралтай ярих тохиолдолд дуудлагыг хүлээн авах утас ажиллуулна.

**11.10** Хүүхдийн амрах өрөөний тавилга, эд хогшлууд хурц ирмэггүй, цахилгаан хэрэгсэл унтраалга, залгуур нь аюулгүй байдлыг бүрэн хангана.

**11.11** Насанд хүрэгчдэд зориулсан үйлчилгээ, амралт, сувиллын газар, согтууруулах ундаагаар үйлчлэх цэг, салбар нь хүүхдийн зуслангийн хамгаалалтын бүсээс 500-аас доошгүй метр зайд байрлана.

**11.12** Хүүхдийн зуслангийн хамгаалалтын бүсийг 11.2-т хамаарах баримт бичигт тодорхойлно.

**11.13** Хүүхдийн зуслангийн бүс нь шатахуун түгээх газраас 2 км-ээс доошгүй зайд оршино.

**11.14** Үерийн хамгаалалт болон халтиргааны аюулгүй байдлыг хангана.

**11.15** Болзошгүй гамшиг, ослын үед эмнэлгийн тусламж, үйлчилгээ үзүүлэх орон тооны хүний нөөц бүрдүүлэх, үүссэн нөхцөл байдалд ажиллах төлөвлөгөө,

## **MNS 5633:2023**

авралтын зам, гарц, бүдүүвч зураг боловсруулан баталж, нийтэд танилцуулах, дадлага, сургуулилалт зохион байгуулж ажиллана.

**11.16** Хүүхдийн зуслангийн үйлчилгээний болон амрах байр нь гамшгийн үед гарах гарц, хаалга, буух шаттай байна. Хэрэв барилга нь давхар бол давхар бүрд ослын үед гарах гарц байна.

**11.17** Аврах хаалга, шатны хонгилд элдэв зүйл хурааж хадгалахыг хориглож, зам гарцыг байнга чөлөөтэй байлгана.

**11.18** Үйлчилгээний болон амрах байранд шатах, тэсэрч дэлбэрэх бодис, шатамхай эд зүйлс хадгалахыг хориглоно.

**11.19** Зуслангийн засвар, үйлчилгээтэй холбогдуулан зайлшгүй шаардлагаар ил гал гаргаж ажил гүйцэтгэх бол аюулгүй байдлын шаардлагыг сайтар хангасан нөхцөлд удирдлага, мэргэжлийн байгууллагын зөвшөөрлөөр тэдний хяналтын дор уг ажлыг гүйцэтгэнэ.

**11.20** Гал тогоонд хийгээр ажиллах төхөөрөмж ашиглах бол хийн баллоныг цахилгаан зуухаас тусдаа агаарын солилцоо сайн явагддаг газарт байрлуулж, аюулгүй ажиллагааны зааврыг ажилтан бүрд өгч, зохих шаардлагын дагуу ажиллана. Ажлын байрны дүгнэлтэд энэ нөхцөлийг тусгаж, зөвшөөрөл авна.

**11.21** Цахилгаан хөгжим, техник төхөөрөмж болон халаалт дулааны систем нь цахилгааны аюулгүй байдлыг хангана.

**11.22** Зуслангийн орчинд аянга зайлуулагч байрлуулна.

**11.23** Зуслангийн үйл ажиллагаа эрхлэгч нь тухайн нутаг дэвсгэрийнхээ цагдаагийн байгууллагатай хамтран, гамшиг эрсдэлээс урьдчилан сэргийлэх төлөвлөгөө гарган, гэрээ байгуулж ажиллана.

**11.24** Зусланд амрагч хүүхдэд хувь хүний гэнэтийн ослын даатгалд болон бусад холбогдох даатгалд хамруулсан байна.

**11.25** Гадаад улсаас зусланд ирж амрах хүүхэд нь гэнэтийн ослын даатгал заавал хамрагдсан байна.

## **12 Хүүхдийн зусланд хориглох зүйл**

Зуслангийн үйл ажиллагаанд хүүхдийн эрх, аюулгүй байдлыг зөрчсөн дараах үйлдлийг хориглоно. Үүнд:

- a) Хүүхдийн эсрэг хүчирхийллийн бүх хэлбэр,
- b) Хүүхдийг ялгаварлан гадуурхах,
- c) Хүүхдээр хүнд хөдөлмөр эрхлүүлэх, хөдөлмөрийн мөлжлөгт өртүүлэх,
- d) Хүүхдэд хүчирхийллийн шинжтэй шийтгэлийн арга хэмжээ хэрэглэх,
- e) Хүүхдийн үнэт эдлэл, мөнгө, эд зүйл зэргийг зөвшөөрөлгүйгээр, хууль бусаар ашиглах, хэрэглэх,
- f) Зуслангийн бүс болон үйлчилгээний байр танхимд тамхи болон согтууруулах ундаа хэрэглэх,
- g) Зуслангийн бүсэд зөвшөөрөлгүйгээр химийн болон спирт, бензин, газ зэрэг хялбар шатах бодис, хутга мэс хадгалах, нэвтрүүлэх,

- h) Зуслангийн бүс, хүүхдийн амрах байрны орчинд гадны хүн зөвшөөрөлгүй нэвтрүүлэх, мал, машин, мотоцикл, дугуй, моторт дугуйтай явах,
- i) Зуслангийн тогтоосон газраас бусад газар зөвшөөрөлгүйгээр түүдэг асаах, галын наадам хийх, Амрагч хүүхдийг зөвшөөрөлгүйгээр ойд зугаалах, самар жимсэнд явуулах,
- j) Амрагч хүүхдийг зуслангийн тогтоосон аюулгүйн бүсээс гадна гол, нуур, цөөрмийн усанд оруулах,
- k) Хүүхдийн ар гэрээс эргэлтээр ирсэн хялбар муудах, хадгалалтын хугацаа нь дууссан, эрүүл ахуй, чанарын шаардлага хангаагүй хүнсний бүтээгдэхүүн, тамхи, согтууруулах ундааны зүйл нэвтрүүлэх,
- l) Мансууруулах эм бэлдмэл, согтууруулах ундаа, тамхи, амрагч хүүхдэд худалдах, сурталчлах,
- m) Хүүхэд амруулж буй өдрүүдэд насанд хүрэгчдийн хөтөлбөрийг давхардуулж зохион байгуулах,
- n) Хүүхдийг шашин, улс төрийн үйл ажиллагаанд оролцуулах, хүүхдэд сурталчлах,
- o) Энэхүү стандартад заасан шаардлага, хэм хэмжээг ханган мөрдөхгүйгээр үйл ажиллагаа явуулах.

**ТӨГСӨВ.**

**А хавсралт  
/норматив/  
Хүүхдийн зусланд тавих норматив шаардлага**

№	Шаардлага	Норм	
1	Байгууллагын зорилго, төлөвлөлт	Байгууллагын нэр, лого бүхий монгол хэл (кирилл болон үндэсний бичиг)-ээр бичсэн хаяг	+
		Зуслангийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл, стандартын тохирлын баталгаа, улсын бүртгэлийн гэрчилгээ	+
		Ажлын байрны болон хүүхдийн чөлөөт цагийн хөтөлбөр үйл ажиллагаа явуулах эрх бүхий байгууллагын зөвшөөрөл, дүгнэлт	+
		Хүүхдийн зуслангийн хэтийн зорилго, төлөвлөлт	+
		Жилийн ажлын төлөвлөгөө, тайлан	+
		Хүний нөөцийн баримт бичиг, ажилтнуудын хувийн хэрэг, тодорхойлолт	+
		Хүүхэд хамгааллын бодлогын баримт бичиг	
		Зуслангийн дүрэм, журам, зааварчилгаа	+
		Хөгжлийн хөтөлбөр	+
		Хөгжлийн хөтөлбөрийн төлөвлөлт, хэрэгжилт	+
		Сэтгэл ханамжийн судалгааны үр дүн, судалгааны мөрөөр ажилласан тэмдэглэл	+
Хууль, тогтоол, шийдвэрийн биелэлт	+		
2	Хүний нөөц	Хүүхдийн эмч	+
		Эрүүл ахуйч эмч (гэрээт байж болно)	+
		Мэргэжлийн тогооч	+
		Биеийн тамир, спортын арга зүйч, багш	+
		Хөгжлийн хөтөлбөр хариуцсан арга зүйч, багш	+
		Соёлын биет бус өвийг өвлөн уламжлагч, арга зүйч	+
3	Хоол үйлдвэрлэл үйлчилгээ	Хоол үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд харьяалах нутаг дэвсгэр дэх хяналтын байгууллагын урьдчилсан хяналтад хамрагдсан дүгнэлт	+
		Хоол үйлдвэрлэлийн өрөө тасалгаа нь хүрэлцээтэй, эрүүл ахуйн шаардлага хангасан, цэвэрлэгээ халдваргүйжлийг хуваарийн дагуу хийж, хөтөлсөн тэмдэглэл	+
		Өдөр тутам бэлтгэсэн бүх төрлийн хоол хүнснээс 150 г-аас багагүй дээжийг авч, ариутгасан саванд хийж битүүмжлэн +4 хэмд 3-аас доошгүй хоног хадгалж, тогтмол хөтөлсөн бүртгэл	+
		Хүнсний бүтээгдэхүүн нь эрүүл ахуй, аюулгүй байдлын шаардлага хангасан, үзүүлэлтийг тодорхойлуулсан шинжилгээний дүгнэлт	+
		Хоолны цэс, технологийн карт	+
		Хүүхдийн цэвэр ус уух боломж бүрдүүлсэн	+
		Усан хангамж төвийн шугамд холбогдсон	+
		Зөөврийн усан хангамж	+
		Халуун боловсруулалтын төхөөрөмж	+
		Механик төхөөрөмж	+
		Материалын хөргөгч	+
		Дээжийн хөргөгч	+
		Баталгаат жин хэмжүүрийн хэрэгсэл	+
		Хөргөлттэй агуулах	+
		Хуурай хүнсний агуулах	+
		Гал тогооны агааржуулалт	+
		Аяга, таваг угаагч болон ариутгагч	+
		Хүнсний тавиур, тогоочийн багаж хэрэгсэл	+
		Ажилтанд зориулсан угааж, халдваргүйтгэх санамж, зааврыг дамжлага бүрд байрлуулсан	+
Ажилтан бүрийг хөдөлмөр хамгааллын хувцсаар бүрэн хангасан	+		
Ногооны агуулах, зорь	+		



		Зоогийн газар	+
		Аж ахуйн үйлчилгээний тээврийн хэрэгсэл	+
4	Хүүхэд тээвэрлэх үйлчилгээ	Зуслангийн захиргаа орон нутгийн тээвэр, авто замын газартай байгуулсан гэрээ	+
		Хүүхэд тээвэрлэх батлагдсан маршрут	+
		Хүүхэд бүрийн тоогоор суудалтай, хамгаалалтын хэрэглэгдэхүүнтэй хүүхдийн аюулгүй байдлыг хангасан тээврийн хэрэгсэл (гэрээт байж болно)	+
		Тусгайлан бэлтгэж, тэмдэгжүүлсэн талбай бүхий автомашины зогсоол (цардмал болон сайжруулан зассан шороон талбай)	+
		Явган хүний болон тээврийн хэрэгсэл явах зам (цардмал болон сайжруулан зассан шороон зам)	+
5	Эрүүл мэндийн үйлчилгээ	Эмчийн үзлэгийн өрөө	+
		Халдварт өвчин гарсан тохиолдолд хэрэглэх 3-аас 5 ортой тусгаарлах өрөө	+
		Анхны тусламж, үйлчилгээнд шаардагдах чанарын баталгаатай эм тариа, боолтын материал, эмнэлгийн хэрэгсэл	+
		Эрүүл мэндийн сургалт сурталчилгааны булан, үзүүлэн таниулах хэрэгсэл	+
6	Хөгжлийн хөтөлбөр үйлчилгээ	Хөгжлийн хөтөлбөрийн баримт бичиг	+
		Хүүхдийн байр болон соёлын танхимд байрлуулсан батлагдсан хөгжлийн хөтөлбөр, сүлжээ төлөвлөгөө	+
		Хөгжлийн хөтөлбөрийн агуулгыг илтгэхүйц тусгайлан тохижуулсан булан, байр, өрөө болон үйл ажиллагаанд шаардагдах хэрэгсэл	+
		Төрөл бүрийн хөгжмийн зэмсэг дагалдах хэрэгсэл	+
		Спорт тоглоомын хэрэглэгдэхүүн	+
		Сагс, гар бөмбөг, хөл бөмбөг болон үндэсний тоглоомын тусгайлан тохижуулсан талбай	+
		Нүүдлийн соёлын боловсрол, морь унах хөтөлбөрийн агуулгыг илтгэхүйц тусгайлан бэлдсэн орчин, морь унаач хүүхдийн хамгаалалтын хувцас, дагалдах хэрэгсэл	+
7	Дотоод орчин, хүүхдийн амрах байр	7-оос 11 настайд 2,5-аас 3,0 м <sup>2</sup> , 11-ээс 16 настайд 3,0-аас 4,0 м <sup>2</sup> оногдох хүчин чадал бүхий, 18-аас 20 хэм дулаантай, 40-өөс 60 хувийн харьцангуй чийгшилтэй, агааржуулалттай, тохижилт, нөхцөл, стандартын шаардлага хангасан амрах байр	+
		Хүүхдэд зориулсан хөгжил, оролцооны үйл ажиллагааг явуулах ариун цэвэр, эрүүл ахуйн шаардлага хангасан зориулалтын агаарын дулаан 18-аас 22 хэм, чийглэг 40-өөс 60 хувь, агаар сэлгэлт хийх боломжтой байр, танхим	+
		Шат довжоог халтиргаанаас хамгаалсан, тусгай хэрэгцээт хүүхэд саадгүй зорчих боломжтой орох, гарах хаалга	+
		Бусад улс, хот сууринтай холбогдох боломж бүхий харилцаа холбоо, мэдээллийн хэрэгсэл	+
		Хүүхдийн насанд тохирсон хагас зөөлөн болон модон ор	+
		Хүүхдийн ширээ, сандал	+
		Хувцасны шүүгээ, өлгүүр	+
		Эрүүл ахуйн шаардлага хангасан, хүрэлцээтэй хөнжил, гудас зөөлөн эдлэл	+
		Нийт амрагч хүүхдийн 20-оос 25 хувьд хүрэлцэхүйц цагаан хэрэглэлийн нөөц	+
		Байгалийн гэрэлтүүлгийн коэффициент нь 1:5-аас багагүй, шалны 1 м <sup>2</sup> талбайд тусах зохиомол гэрэлтүүлэг нь ердийн гэрэл 5 ватт, өдрийн гэрэл 16 люксээс багагүй хэмжээтэй байх	+
Амрах өрөөний цахилгааны аюулгүй байдал	+		

		Амрах өрөөний цонх, хаалганы шил, толины аюулгүй байдлыг хангасан байдал	+
8	Гадна орчин, барилга байгууламж	Хүүхдийн зуслан өөрийн өмчийн эсвэл эзэмшил газар	+
		Зуслангийн өмчийн, эзэмшлийн газарт гаднын объект байхгүй, хамгаалалт бүхий хашаа	+
		Шалган нэвтрүүлэх байр, харуул манаачийн байр	+
		Ажилтнуудын хувцасны өрөө	+
		Ажилтнуудын байгууллагын бэлгэдэл бүхий нэг загвар хийцийн хувцас, энгэрийн нэрийн тэмдэг	+
		Ажилтнуудын ариун цэврийн өрөө	+
		Цагаан хэрэглэлийн агуулах	+
		Төвлөрсөн болон бичил системд холбогдсон ариун цэврийн өрөө	+
		15 хүүхдийн дунд нэг эрүүл ахуйн шаардлага хангасан гарын угаалтуур	+
		20 хүүхдэд 1 шүршүүр бүхий эрүүл ахуйн шаардлага хангасан халуун усны өрөө	+
		10 хүүхэд тутамд нэг суултуур бүхий эрүүл ахуйн шаардлага хангасан био ариун цэврийн өрөө	+
		Цэвэрлэгээ, халдваргүйжүүлэлтийг тогтмол хийж, бүртгэл хөтөлдөг, загвар, хэмжээс нь стандартын шаардлага хангасан био бие засах газар	+
		Аюулгүй байдлын шаардлага хангасан халаалт, дулааны систем	+
		Галын дохиоллын систем, гал унтраах төхөөрөмж, багаж хэрэгсэл	+
		Аянга зайлуулагч	+
		Хяналтын камер	+
		Ус зайлуулах хоолой	+
		Мэдээллийн архив	+
		Хогийг ялгаж хаях цэг байршил	+
		Ажилтнуудын орон сууц	+
Барилга хооронд шөнийн гэрэлтүүлэг	+		

## Ном зүй

- Нэгдсэн Үндэсний Байгууллага (НҮБ) Хүүхдийн эрхийн тухай Конвенц;
- НҮБ-ын Хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрийн тухай Олон Улсын хөдөлмөрийн Байгууллагын 182 дугаар конвенц;
- НҮБ-ын Хүүхдийн эрхийн тухай конвенцын Хүүхдийг худалдах, хүүхдийн биеийг үнэлэх, хүүхдийг садар самуунд сурталчлахын эсрэг нэмэлт протокол;
- НҮБ-ын Хүүхдийн эрхийн тухай конвенцын Мэдээлэл хүргүүлэх журмын тухай нэмэлт протокол;
- Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенц
- Хүүхэд хамгааллын бодлогын жишиг баримт, 2018 он;
- Монгол Улсын замын хөдөлгөөний дүрэм;
- Авто тээврийн хэрэгслээр ачаа, зорчигч тээвэрлэх дүрэм. 2009 он;
- Нэгээс арван есөн настай хүүхдийн хоолны илчлэг, эрдэс бодисын норматив. Эрүүл мэндийн сайд, Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2005 оны 225/295 тоот тушаал;
- Хоолны газрын нийтлэг журам, Хүнс хөдөө аж ахуйн сайдын 2010 оны 206 дугаар тушаал;
- Тусгай хоолны дэглэмтэй хүн, нярай, бага насны болон цэцэрлэгийн хүүхэд, ерөнхий боловсролын бага ангийн сурагчдад зориулсан хүнсний түүхий эд, бүтээгдэхүүн, хоол үйлдвэрлэлд тавих шаардлага, түүнийг тогтоох журам, Эрүүл мэндийн сайдын 2013 оны 207 тоот тушаал;
- Хүүхдийн эрх, хамгааллын тухай Засгийн газрын тогтоол, тушаал, журам;